



**НИЙСЛЭЛИЙН БАЯНГОЛ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2021 оны 03 сарын 04 өдөр

Дугаар А/89

Улаанбаатар хот

Шуурхай штабыг сунган ажиллуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.7, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8 дахь заалт, Засгийн газрын 2020 оны 238 дугаар тогтоол, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаал, Нийслэлийн Засаг даргын 2021 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн А/06 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын хэмжээнд Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгасантай холбогдуулан, шинэ коронавируст (Ковид-19) цар тахлаас урьдчилан сэргийлэх ажил, хяналт шалгалт явуулахтай холбоотой мэдээ, мэдээллийг нэгтгэн дамжуулах, дуудлага, мэдээллийн дагуу ажиллах үүрэг бүхий шуурхай штабыг 2021 оны 03 дугаар сарын 01-нээс 2021 оны 03 дугаар сарын 31-ний өдрийг дуустал сунгаж ажиллуулсугай.

2. Шуурхай штабын ажиллах журмыг, нэгдүгээр хавсралтаар, шаардагдах зардлыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Шуурхай штабын үйл ажиллагаанд шаардагдах 4,195,000 (дөрвөн сая нэг зуун ерэн таван мянга) төгрөгийг хавсралтаар баталж, Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Тамгын газрын Ахлах нягтлан бодогч Б.Хонгорзулд зөвшөөрсүгэй.

4. Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагааг нь хязгаарласан жагсаал, цуглаан, аялал зугаалга, тэмцээн уралдаан, өргөтгөсөн үзэсгэлэн худалдаа, аялал зугаалга (гэр бүлээс бусад) диско баар, цахим тоглоом, хүүхдийн тоглоомын төвүүд ажиллахыг Мэргэжлийн хяналтын хэлтэс(Б.Идэрбат)-т, Цагдаагийн газар (М.Батсайхан)-т тус тус даалгасугай.

5. Шуурхай штабт ажиллах жижүүрийн бүрэлдэхүүнийг 24 цагаар үүрэг гүйцэтгэхээр томилон, шуурхай штабтай хамтран ажиллаж, өдөр тутмын явцын мэдээ, мэдээллийг штабын 70120318 дугаарын утсанд 14:00, 20:00 цагуудад, нэгдсэн мэдээг 08:00 цагт өгч, өгөгдсөн үүрэг чиглэлийг хэрэгжүүлж ажиллахыг Эрүүл мэндийн төв (З.Балдандугар)-д даалгасугай.

6. Дүүргийн нутаг дэвсгэрт урьдчилан сэргийлэх эргүүл, хяналт шалгалтаар ажиллаж байгаа бүрэлдэхүүн эргүүлийн нэгдсэн мэдээг 18:00 цагт шуурхай штабт өгч ажиллахыг харьяа хэлтэс, албадын дарга нарт үүрэг болгосугай.